

**VIII АНГИЙН МОНГОЛ ХЭЛ БИЧИГ, УРАН ЗОХИОЛЫН АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН
МАТЕРИАЛ**

Хувилбар А

Хугацаа: 60 минут

Нийт оноо: 20

Анги:.....

Овог:..... Нэр:.....

Тогоруу

Тогоруу гэдэг гэдэн алхана. Газар цөмлөчих вий гэж ийнхүү гэтэж явдаг гэж хүмүүс дооглодог юм. Усны шувуу гэх боловч ихэвчлэн тал, хээр нутагт тааралддаг. Үүр ноохойд нь дөхөж очиход гүйж ирээд далавчаа дэвсэн тонголzon бөхөлзөж, ая тал засах нь зөвлөн сэтгэлт хүнийг зүг чигээ өөрчлөхөөс өөр аргагүйд хүргэдэг. Ихэвчлэн 2 өндөг гаргана. Монголчууд үр хүүхдэдээ шувууны үүрэнд сүүдрээ бүү хүргэ. Эх нь тоохоо больж, хүүхдүүд нь харангадаж үхдэг гэж сургадаг бөлгөө. Басхүү тогорууны үүрийг нь сандаачиж, өндгийг нь няцалбал төмөр дөрөө сэтэртэл хараадаг гэдэг.

Тогоруу ихэвчлэн ургамлын гаралтай зүйлээр хооллох боловч шавж, авгалдайг ч бас иднэ. Намар тариа боловсрох үед тариан түрүүгээр хооллох нь ихэснэ. Тариан талбай үтрэм бараадаж, хэдэн зуугаараа цуглардаг гэнэ.

Өдрийн аагим халуун эхлэхэд шонгийн модны сүүдэрт эцэг эх шувуу 2 бор дэгдээхийн хамт сүүдэр даган цувраад жагсчихсан байгаа харагддаг. Хэд хоногийн халуунд чив чимээгүй байснаа гэнэт нэг өдөр агаарт эргэлдэн ганганалдаж эхлэхэд “Тогорууны бөгс хатжээ, тэнгэрээс хур дуудаад эхэллээ, ашгүй борооших байгаа” гэцгээдэгсэн. Үнэхээр маргаашаас нь бороо орж эхэлнэ дээ. Үүнийг бороо дөхөхөөр агаар дахь чийг дуслын хэмжээ ихсэж, газар байснаас тэнгэрт байсан нь хамаагүй сэргүүхэн болдготой холбон тайлбарлаж болох юм. Хөдөөний хүүхдүүд сүрэглэн алхах тогорууг харж

Тогоруу сайхан

Тоодог муухай

Тогоруу, тогоруу

Цам харай, цам харай гэж хашхиралддаг. Үүнийг сонсоод тогоруунууд үнэхээр хөдөлгөөнд ороод явчих шиг санагддаг. Далавчаа дэвж гэдэлзэж, годолзож гүйгээд л. Тэгэхээр энэ нь хүүхдүүдийн үгэнд онгироод цам харайгаад байгаа юм шиг. Өөр лүү нь харж хашхиралдаад байхад ямар ч амьтад түгшүүр төрж үймэлдэлгүй яах вэ дээ.

Харин жинхэнэ цам харайх нь өөр учир явдалтай юм. Тогоруунууд хавар ирснийхээ дараа олноороо цугларч, эр нь эм шувуудаа бүжигт урих мэт элэн халих хөдөлгөөн хийж, нисэх, гүйх хоёрыг хослуулан бүжихийг цам харайх гэдэг. Цам харайх бүжиг 2-3 хоног үргэлжлэх бөгөөд энэхүү “таанц”-аас тараахдаа ижил хания олцгоож, хос хосоороо хорвоогийн зүг зүг ийш тийш нисэн одоцгоодог ажээ.

Ж.Мягмарсүрэн

1. Эхээс дараах хүснэгтэд тохирох жишээг олж бичээрэй.

[2 оноо]

Эхээс тохирох жишээ	
БАРИМТ	

**ЗОХИОГЧИЙН
ҮЗЭЛ БОДОЛ**

2. Дараах үгсийн утгыг тайлбарлан бичнэ үү. [2 оноо]

Дооглох.....

Дөрөө.....

3. Дараах хоёр өгүүлбэрийг холбох үг ашиглан шалтгааны утгатай нийлмэл өгүүлбэр болгож хувиргаарай. [2 оноо]

Монголчууд үр хүүхдэдээ шувууны үүрэнд сүүдрээ бүү хүргэ. Эх нь тоохоо болж, хүүхдүүд нь харангдаж үхдэг гэж сургадаг бөлгөө.

4. Өгүүлбэрийн онцолсон бүтээврийг ойролцоо утгатай бүтээврээр солин найруулж бичээрэй. [2 оноо]

Басхүү тогорууны үүрийг нь сандаачиж, өндгийг нь няцалбал тэмэр дөрөө сэтэртэл хараадаг гэдэг.

авдар+ын=..... Дүр
Эм.....

бусад+д=..... Дү
рэм.....

6. Үндэсний бичгээс кирилл бичигт хөвүүлэн бичээрэй. [5 оноо]

Хүн ашиг
Хүн ашиг
Хүн ашиг
Хүн ашиг
Хүн ашиг
Хүн ашиг
Хүн ашиг

7. Дараах зохиолын хэсгийг зохиолтой нь зөв харгалзуулаарай. [5 оноо]
1. П.Лувсанцэрэн "Усны эргүүлэг буюу Борзооны явдал" А. Өвгөн хэмхэрхий
араг сандайлан, тэнгэрийн
хаяа ширтэн суув.
2. Б.Ринчен "Монгол хэл" Б. ...Хүүхдүүд энд тэндгүй хурхирч
хаяагаар хүйтэн салхи сийгнэ. Сэмбэн бас
л ирдэггүй.
3. Д.Намдаг "Үрэгдсэнийг хүлээгч" В. Удам залгасан нутгийнхаа хаанаас ч
Худам бичгийнхээ дүрсийг үгүйлдэг
4. С. Дулам "Хүмүүн бичиг" Г. Зуны амралтаараа Цайдам ахыг олж
уулзаад, зургуудаа үзүүлнэ. Би урам ороод
зав л гарвал шог зураг зурж байдаг болов.
5. Ж. Барамсай "Цүнхтэй инээд" Д. Сод их билэгт түмэн юүгээн
бишрэн магтмуу би!

АМЖИЛТ ХҮСЬЕ!



VIII АНГИЙН МОНГОЛ ХЭЛ БИЧИГ, УРАН ЗОХИОЛЫН АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН МАТЕРИАЛ

Хувилбар Б

Хугацаа: 60 минут

Нийт оноо: 20

Анги:..... Овог:..... Нэр:.....

ШОРГООЛЖНЫ ЦОХ

Шоргоолжны цох нь шоргоолжны бутны байнгын зочин ажээ. Шоргоолж цохыг үзмэгц үндсэн үүргээ мартдаг. Судлаачид анх ойн улаан шоргоолжны үүрийг малтахдаа маш хачин гайхамшигтай цох олжээ.

Түүний биенийн урт ердөө 5-6 мм хэмжээтэй, улаан шаргал- хүрэн өнгөтэй, урд далавч нь гялалзсан, богинохон. Цох гавшгай хөнгөн хөдөлгөөнтэй. Шоргоолжтой учрангуут сахлаараа ороолгоно. Шоргоолж хэчинээн их яарч байсан ч тэр дороо зогсож хоолоо гулгин гаргаж цохыг хооллоно.

Ийм цохнуудыг "Шоргоолжны цох" гэж нэрлэдэг байна. Тэдгээр нь шоргоолжны үүрнээс өөр хаана ч байдаггүй ажээ.

Эцэст нь байгаль судлаачид хиймэл үүр засаж шоргоолжны байранд болж буй бүх юмыг шилэн хананы цаанаас ажиглан хачин гайхалтай зүйлийг олж харсан байна.

Шоргоолжнууд цох руу ээлж дараагаар гүйн очиж түүний хэвлийн хажуунаас гарсан нарийхан үсийг татлан, дамжин урсах ямар нэгэн шингэн дуслыг долоож байжээ. Заримдаа шоргоолжнууд цохыг тойрон бөөгнөрч, бие биенийгээ түлхэн тэрхүү үсэнд түрүүлэн хүрэхээр өрсөлдөцгөөнө.

Бас нэгэн гайхамшиг нь шоргоолжнууд цохны авгалдайг үр төлийнхөө адил асран арчилдаг байна. Харин өрөвдөхөөр өр өшиглөнө гэгчээр цохны авгалдайнууд шоргоолжны өндгийг сорж иддэг болохыг судлаачид ажиглан мэдэцгээжээ.

Хүчтэй дайсан довтолж аюул учирсан үед шоргоолж эхлээд цохны авгалдайг авраад дараа нь өөрийнхийгээ авардаг ажээ. Шоргоолжны энэ өглөгч зан нь хязгааргүй юм. Тэд бусад эмэгчин шоргоолжны өндгөөр цохны авгалдайг хооллоод зогсохгүй өөрийн авгалдайн хоолыг ч булаан авч өгдөг. Энэ мэт зочломтгой зангаасаа болж зарим шоргоолж өөрөө өлсөж туйлдан, үр тел ч өгөхгүй байсаар үхэж үрэгддэг. Ингэхэд шоргоолжны цох өөртөө шоргоолжнуудыг юугаар их татдаг юм болoo.

Шинжлэх ухаанд трихом гэж нэрлэдэг шар хялгасан үс цохны хэвлий, биенийн бусад хэсэгт ч бас ургадаг байна. Тэр шар хялгасны доор байдаг арьсны булчирхай, өөхлөг эдээс шүүрэл хэмээгч анхилуун үнэртэй, агаарт амархан тархдаг шингэн ялгардаг.

Химиин бүтцээрээ эфиртэй их төстэй бололтой. Түүний хойноос л шоргоолжнууд хөөцөлддөг ажээ.

1. Шоргоолжны цохны гадна төрх, байдлыг илэрхийлсэн баримт 2-ыг олж бичээрэй.
[2 оноо]

Эхээс тохирох жишээ	
БАРИМТ-1	
БАРИМТ-2	

2. Эхэд байгаа доорх үг хэллэгийн утгыг тайлбарлана уу. [2 оноо]

Гулгих.....

Хялгас.....

3. Дараах хоёр өгүүлбэрийг холбох үг ашиглан шалтгааны утгатай нийлмэл өгүүлбэр болгож хувиргаарай. [2 оноо]

Химиин бүтцээрээ эфиртэй их төстэй бололтой. Түүний хойноос л шоргоолжнууд хөөцөлддөг ажээ.

4. Дараах шалтгааны утгатай өгүүлбэрийн онцолсон бүтээврийг ойролцоо утгатай бүтээврээр солин найруулж бичээрэй. [2 оноо]

Шоргоолжтой учрангуут сахлаараа ороолгоно.

5. Дараах гадаад үгсэд тохирох нөхцөлийг бичээрэй. [2 оноо]

нөхөд+д=.....Дү
рэм.....

чадал+аас=.....Дү
рэм.....

6. Үндэсний бичгээс кирилл бичигт хөвүүлэн бичээрэй. [5 оноо]

Үүшүү
Чадал
Тэдэл
Задал
Хадал

.....
.....
.....
.....
.....
.....
.....

7. Дараах зохиолын хэсгийг зохиолтой нь зөв харгалзуулаарай. [5 оноо]

- | | |
|---|---|
| 1. Ж. Барамсай "Цүнхтэй инээд" | A. Намрын дунд сарын
арван таван гэж Жамьян хариулав. |
| 2. Явуухулан "Тэхийн зогсоол" | B. Нумын хөвч шиг бичиг минь
үгүй бол
Нууц товчоогоо юугаар бичих вэ? |
| 3. Д. Намдаг "Үрэгдсэнийг хүлээгч" | C. Хараач ээ, хүүхдүүд ээ!
Манай шог зураач, Бордухыг ингэж
матарласан байна... |
| 4. П. Лувсанцэрэн "Усны эргүүлэг буюу Борзооны явдал" | D. ...Нямжавтай
миний ингэж дэмий ярьж
байгаа маань хоолны дун
дуугархыг хүлээж цаг
нөгчөөж суугаа хэрэг. |
| 5. С. Дулам "Хүмүүн бичиг" | E. ...Янгир өтлөхөөрөө эврээ даахаа
Больдог юм гэнэ лээ. |